



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/395


Ховд

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулахаар хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын хийсэн үнэлгээ, комиссын шийдвэрийг үндэслэн согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрлийг хавсралтаар заасан аж ахуйн нэгжүүдэд олгосугай.

2. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчилгээ явуулах асуудалд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий комисс (Т.Дэлгэрсайхан), Цагдаагийн газар (Д.Мөнхболд), Мэргэжлийн хяналтын газар (П.Эрдэнэчулуун), Стандартчлал хэмжил зүйн хэлтэс (Б.Гомбосүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.



Б. ДҮГЭРЖАВ



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН СУНГАЛТ
ХИЙХ АЖ АХУЙ НЭГЖИЙН НЭРС**

№	Аж ахуйн нэгжийн нэр	Худалдаа үйлчилгээний төрөл	Эзний нэр	Харьяалал	Авсан оноо (хувиар)
1	"МНДЭТ" ХХК	Хүнсний дэлгүүр	З.Мягмаржаргал	Баатархайрхан баг	94
2	"Жаргалант цахиур" ХХК	ресторан	М.Нарангарав	Наран баг	91
3	"Гэрэлт чандмань" БГБХ	Хүнсний дэлгүүр	Б.Сэр-Од	Цамбагарав баг	91,3
4	"Гүмүда-Өргөө" ХХК	Хүнсний дэлгүүр	Б.Цэнгэл	Бичигт баг	90
5	"Хос алтайн оргил" ХХК	Хүнсний дэлгүүр	Д.Ганбат	Бугат баг	91,6
6	"Минжит булган мандал" ХХК	Зоогийн газар	М.Мөнхцэцэг	Булган сум	85,6
7	"Том хантэр" ХХК	Паб, ресторан	Н.Мөнхтулга	Хайрхан баг	
8	"Ховд ачаа тээвэр" хоршоо	Хүнсний дэлгүүр	Ж.Дамбий	Наран баг	90
9	"ГАНГСТ" ХХК	Хүнсний дэлгүүр	Б.Соронзон тулга	Наран баг	91,3
10	"Грөүв-Ап" ХХК	Хүнсний дэлгүүр	Б.Отгонбаяр	Цамбагарав баг	90
11	"Буурал хайрханы хужирт" ХХК	Хүнсний дэлгүүр	А.Мөнхдаваа	Магсажав баг	92,3
12	"Буянт бүтээл" ХХК	ресторан	С.Мөнх-Оргил	Тахилт баг	90,5
13	"Үлэмж инга" ХХК	Хүнсний дэлгүүр	Н.Олонбаяр	Алаг толгой баг	93